



**Арилжааны мэдээ**

- 2017 оны 50 дахь долоо хоногт Монголын хөрөнгийн биржээр нийт 1.56 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдлаа.
- Тус долоо хоногт MSE Top-20 индекс 7.02% буурч 21,495.97 нэгжид хүрсэн бол MSE All индекс 5.22% буурч 1,166.71 нэгжид хүрлээ.
- Нийт 69 компанийн 2,927,385 ширхэг хувьцаа 1,548,896,540.46 төгрөгөөр арилжаалагдсан байна.
- ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн нийт 8 удаагийн хэлцлээр 79 ширхэг үнэт цаас 7,628,000 төгрөгөөр арилжаалагдлаа.
- Хамгийн их өсөлттэй хувьцаагаар Хүннү менежмент (HBZ) 32.15% өсч 11.55 төгрөг, Материал импекс (MIE) 21.86% өсч 21.86 төгрөгт тус хүрч хаагдлаа.
- Хамгийн их бууралттай хувьцаагаар Увс чацаргана (CHR) 15.00% буурч 1,020 төгрөг, Нэхээсгүй эдлэл (NXE) 14.97% буурч 2,550 төгрөг, Э-транс ложистик (ETR) 14.40% буурч 68.78 төгрөгт хүрч хаагдлаа.

MSE Top 20 индекс

Эх сурвалж: BDSEC

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа

Эх сурвалж: Монгол Банк

	USD/MNT ханш	% Өөрчлөлт
USD	2434.22	0.16

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	21,495.97	-7.02%
MSE All индекс	1,166.71	-5.22%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,459,872,085,930
Арилжигдсан үнийн дүн	1,560,124,540

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
АПУ	717.54	966,517,228
ТАВАН ТОЛГОЙ	8,960	148,903,975
ГОВЬ	27,380	84,329,800
МОНГОЛ ШУУДАН	606.88	80,739,347
ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	500.01	76,117,321

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
АПУ	717.54	1,269,130
РЕМИКОН	38	900,310
АЙТҮҮЛС	197.15	246,603
ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	500.01	152,231
МОНГОЛ ШУУДАН	606.88	144,877

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	11.55	32.15
МАТЕРИАЛ ИМПЕКС	10,900	21.86
ЖЕНКО ТУР БЮРО	64	16.47
ЖИНСТ УВС	576.15	15.00
БАЯНТЭЭГ	12,650	15.00

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
УВС ЧАЦАРГАНА	1,020	15.00
НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	2,550	14.97
Э-ТРАНС ЛОЖИСТИК	68.78	14.40
ГОВЬ	27,380	14.38
БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	1,800	13.04

ЗЗҮнэлгээ өндөр	Хаалт (MNT)	Тэрбум/₮
АПУ	717.54	763.59
ТАВАН ТОЛГОЙ	8,960	471.88
ГОВЬ	27,380	213.59
МИК ХОЛДИНГ	10,000	207.09
СҮҮ	239.74	82.47

Дараах link-ээр орж арилжааг харна уу: <http://bdsec.mn/trade/>

**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ****“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН АРИЛЖААГ****СЭРГЭЭЛЭЭ** (mse.mn)

- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 222 дугаар тогтоолоор “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа хуваахтай холбоотой өөрчлөлтийг үнэт цаасны бүртгэлд оруулсан тул тус компанийн арилжааг 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс нээснийг мэдэгдэж байна.

“ДАВААНБУЛАГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**(mse.mn)**

- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Даваанбулаг” ХК нь 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд энэхүү шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүсэнийг үүгээр мэдэгдэж байна.
- Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо: 2016 оны 4-р сарын 10-ний өдөр
- Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2018 оны 1-р сарын 24-ний өдрийг хүртэл
- Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: 179 төгрөг
- Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол “Даваанбулаг” ХК болон өөрийн харилцагч брокерын компанид хан хандана уу.
- Шаардах эрх хэрэгжүүлэгч “Даваанбулаг” ХК: УБ, БГД, 4-р хороо 2-р хороолол, ТЗЭ-ийн “АСТРА” төвийн 2-р давхар холбогдох утас: 99701050, 96811008

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН” ХК “ЖИНСТ УВС” ХК-ТАЙ НЭГДЭЖ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО**(mse.mn)**

- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 11 сарын 24-ний өдрийн 225 тоот тогтоолоор “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” хаалттай хувьцаат компани нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй “Жинст Увс” ХК-тай нэгдэж нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд өнөөдөр уг компанийн арилжааны нээлт болон цан цохих үйл ажиллагаа болж өнгөрлөө. Цан цохих үйл ажиллагаанд МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг болон “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тамир нар оролцож, МХБ-ийн 5,620 дахь арилжааг эхлүүлж хүндэтгэлийн цанг цохилоо.
- “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК нь 2016 оны 1 дүгээр сард 560 хүний санаачлагаар Монголд анх удаа “crowdfunding” /олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх/ аргыг ашиглан олон нийтийн оролцоотой арилжааны банк байгуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан мэргэжлийн санхүү, хөрөнгө оруулалтын компани бөгөөд өдгөө 900 гаруй үндэсний хөрөнгө оруулагч иргэд, аж ахуйн нэгжийг эгнээндээ нэгтгээд байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Ард Санхүүгийн Нэгдлийн 7 орчим хувийг эзэмшдэг бөгөөд цаашид Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Монголын банк санхүүгийн салбарыг дэлхийн цахим хувьсгалд хамруулах зорилготой ажиллаж байгаа тухайгаа нээлтийн үеэр мэдэгдлээ.

“НОГООН СУМ” ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ РЕАЛИТИ ШОУ**НЭВТРҮҮЛЭГ ЭХЭЛЛЭЭ** (mse.mn)

- Иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг нэмэгдүүлэх болон хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох тухай мэдээллийг олон нийтэд богино хугацаанд

- сонирхолтой, үр дүнтэйгээр хүргэх үүднээс “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь “Монголын үндэсний олон нийтийн радио телевиз”-тэй хамтран “Ногоон сум” реалити шоу-го зохион байгуулж, 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн орон даяар нэвтрүүлж эхэллээ.
- Уг реалити шоу нэвтрүүлэгт ХЗЗ-ийн арилжаанд оролцож байгаагүй олон нийтийн төлөөлөл болох 5 оролцогч оролцох бөгөөд мэргэжлийн зөвлөх байгууллагуудаас зөвлөгөө авсны үндсэн дээр “Монголын хөрөнгийн бирж” дээрээс үнэт цаас худалдан авч оролцоно. Нэвтрүүлэг нь тус бүр 40 минут үргэлжлэх 7 удаагийн дугаараас бүрдэх бөгөөд нэвтрүүлгийн эцэст хөрөнгө оруулалтын багцаа хамгийн ихээр өсгөсөн оролцогч нь ялагч болно.
- Хөрөнгийн зах зээл нь зах зээлийн ерөнхий төлөв байдал болон хувьцаат компанийн үйл ажиллагаатай уялдан өсч буурч тогтмол хэлбэлздэг бөгөөд үнэт цаасанд хөрөнгө оруулснаар оролцогчдын хөрөнгө оруулалтын багц нь өсөх, буурах аль аль нь магадлалтай юм. Нэвтрүүлэг нь зах зээлийн ач холбогдол, хөрөнгөө өсгөх боломжийг төдийгүй мөн эрсдэлийг нь ч үнэн бодитоор үзэгчдэд хүргэх зорилготой билээ.

Үнэт цаасны компаниудын оролцоо

Монголын хөрөнгийн бирж 2017 оны 12 дугаар сарын 11-нээс 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, нийт 1,560,124,540.46 төгрөгийн арилжаа хийж, өдөрт дунджаар 312.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Хувьцааны арилжаа:

ИДЭВХТЭЙ ХУВЬЦААНЫ АРИЛЖАА ЯВУУЛСАН ҮЦК-УУД

ҮЦК-ийн нэр	Үнийн дүн
Блүмсбюри секюритиес ХХК	701,727,877
Стандарт инвестмент ХХК	547,062,289
Ти Ди Би Капитал ХХК	248,570,057
Голомт Капитал ХХК	244,613,872
БиДиСек ХК	234,337,726

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн нийт 8 удаагийн хэлцлээр 4,054 ширхэг үнэт цаас 416,672,720 төгрөгөөр арилжаалагдлаа.

Засгийн газрын 2догч зах зээлийн арилжаа

ИДЭВХТЭЙ ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ЯВУУЛСАН

ҮЦК-ийн нэр	Үнийн дүн
Гаули ХХК	13,534,000
Ти Ди Би Капитал ХХК	861,000
Голомт Капитал ХХК	861,000

Жич: Авсан зарсан нийлбэр үнийн дүнгээр гаргав.



БИДИСЕК ХК

О.Уранбайгал

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Б.Билгүүн

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: bilguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Э.Алтансүх

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: darkhan@bdsec.mn

БиДиСек Дархан

Дархан-Уул аймаг, Монгол улс
Утас: +976-94082846

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.